

**“МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН
ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ АСУУДЛААР ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2016 оны 08 дугаар
сарын 25-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2016 оны 08 дугаар сарын 23-ны өдөр “Монгол Улсын Засгийн газраас 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо уг асуудлыг 2016 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Улсын Их Хурлын 7 дахь удаагийн ээлжит сонгуулийн үр дүнд шинээр байгуулагдсан Монгол Улсын Засгийн газар нь “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөр, иргэний нийгмийн байгууллагууд, иргэд сонгогчдын санал, олон улсын гэрээ хэлэлцээрийг үндэслэн 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөө боловсруулжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр нь Эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого, Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого, Нийгмийн бодлого, Байгаль орчин ногоон хөгжлийн бодлого, Засаглалын бодлого гэсэн 5 үндсэн бүлэгт 381 зорилт дэвшүүлсэн бөгөөд Монгол Улсад бий болсон эдийн засаг, санхүүгийн хүнд нөхцөлд улс орныхоо эдийн засгийг богино хугацаанд сэргээж, өсөлтийг бий болгон нийгмийн салбаруудыг дэмжиж, иргэдийнхээ аж амьдралыг сайжруулах, төрийн албыг чадавхжуулах, бүх шатанд мэргэшсэн албан хаагчидтай байж, төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, ил тод, нээлттэй үзүүлэх, нийгмийн итгэлцлийг бэхжүүлэн улс үндэстний аюулгүй байдлыг баталгаажуулахад чиглэгдсэн байна.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү, Д.Лүндээжанцан, Л.Оюун-Эрдэнэ нар хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан асуулт асууж, хариулт авсан бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Д.Хаянхярваа Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг тооцоо судалгаанд үндэслэн бодит амьдралд нийцүүлэн боловсруулж, эдийн засгийн хямралаас богино хугацаанд гаргах, одоогийн нөхцөл байдлаас хэт давсан зүйлийг мөрийн хөтөлбөрт төлөвлөхгүй байх, албан тушаалтнуудын буруутай үйл ажиллагаанаас болж төрд гаргасан хохиролыг бодитоор тооцож нөхөн төлүүлэх механизмыг бий болгоход анхаарах нь зүйтэй гэсэн саналыг гаргав.

“Монгол Улсын Засгийн газраас 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон


гишүүдийн олонхи дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Засгийн газраас 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА



Н.ЭНХБОЛД